



БАГАНУУР ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



---

Танаа

# **БАГАНУУР ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН БАЙДАЛ**

*/2014 оны эхний 8 сар/*

*/албан ёсны статистик мэдээллээр бэлтгэсэн танилцуулга/*

2014 он

ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН  
ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД



Хүснэгт 1. Жил бүрийн эхний 8 сарын байдлаар

	Хэмжих нэгж	2008	2009	2010	2011	2012	2013	2014
Суурин хүн ам	тоо	25877	25875	26905	27036	27440	27936	
Шинээр төрсөн хүүхэд	тоо	458	471	417	420	473	581	516
Нас баралт	тоо	123	102	118	134	104	123	127
Шилжиж ирсэн	тоо	741	658	896	578	583	651	717
Шилжиж явсан	тоо	1221	1058	1129	770	671	828	781
Ажилгүйчүүд	тоо	409	651	788	541	376	479	360
Халдварт өвчин	тоо	568	380	350	362	373	399	286
Бүртгэгдсэн гэмт хэрэг	тоо	219	205	183	166	184	197	160

**АЖ ҮЙЛДВЭР:** Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэлт 2014 оны эхний 8 сарын байдлаар 60.3 тэрбум төгрөг байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 1.9 хувиар буюу 1.2 тэрбум төгрөгөөр буурсан байна.

**Хүснэгт 2. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт**

Үзүүлэлт	Нийт үйлдвэрлэлт /биет хэмжээгээр/			Нийт үйлдвэрлэлт /үнийн дүнгээр, мянган төгрөг/		
	2013 он	2014 он	өсөлт бууралт	2013 он	2014 он	өсөлт бууралт
Нүүрс олборлолт	2306.0	2045.1	-260.9	47273000.0	46014750.0	-1258250.0
Дулаан дамжуулалт	95.0	95.8	0.8	1743072.5	1841265.4	98192.9
Талх үйлдвэрлэлт	46.8	60.9	14.1	59071.7	77730.2	18658.5
Нарийн боов үйлдвэрлэлт	70.8	94.7	23.9	146084.1	198830.5	52746.4
Арматур	12589.0	12267.0	-322.0	12301075.0	12206540.0	-94535.0



Тайлант хугацааны аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийг /биет хэмжээгээр/ өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад талх үйлдвэрлэлт 30.1 хувиар буюу 14.1 тонноор, нарийн боов үйлдвэрлэлт 33.8 хувиар буюу 23.9 тонноор, дулаан дамжуулалт 0.8 хувиар буюу 0.8 мянган гкал-аар тус тус өссөн бол нүүрс олборлолт 11.3 хувиар буюу 260.9 мянган тонноор, арматур үйлдвэрлэлт 2.6 хувиар буюу 322.0 тонноор тус тус буурсан байна.




Харин аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийг үнийн дүнгээр өнгөрсөн оны мөн үетэй харьцуулж үзэхэд талх үйлдвэрлэлт 31.6 хувиар буюу 18.6 сая төгрөгөөр, нарийн боов үйлдвэрлэлт 36.1 хувиар буюу 52.7 сая төгрөгөөр, дулаан дамжуулалт 5.6 хувиар буюу 98.2 сая төгрөгөөр тус тус өссөн бол, нүүрс олборлолт 2.7 хувиар буюу 1258.3 сая төгрөгөөр, арматур үйлдвэрлэлт 0.8 хувиар буюу 94.5 сая төгрөгөөр тус тус буурсан үзүүлэлттэй

байна.

**НИЙГМИЙН ДААТГАЛ:** 2014 оны эхний 8 сарын байдлаар нийгмийн даатгалын сангийн орлого 5432.0 сая төгрөг болж өнгөрсөн оны мөн үеийнхээс 2.0 хувиар буюу 112.9 сая төгрөгөөр буурсан бол зарлага 11141.8 сая төгрөгт хүрсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 20.7 хувиар буюу 1917.2 сая төгрөгөөр өссөн байна.

Нийт орлогын 61.6 хувь буюу 3347.5 сая төгрөг тэтгэврийн санд, 6.8 хувь буюу 372.9 сая төгрөг тэтгэмжийн санд, 1.7 хувь буюу 91.0 сая төгрөг ажилгүйдлийн санд, 10.8 хувь буюу 586.1 сая төгрөг ҮОМШӨ санд, 19.1 хувь буюу 1034.5 сая төгрөг нь эрүүл мэндийн даатгалын санд тус тус төвлөрсөн байна.

Зураг 4. Нийгмийн даатгалын сангийн орлогын бүрдэлт




**Хүснэгт 3. Нийгмийн даатгалын сан**

Үзүүлэлт	2013 он		2014 он	
	Хүний тоо	Сая төгрөг	Хүний тоо	Сая төгрөг
Сангийн орлого бүгд		5544.9		5432.0
үүнээс: тэтгэврийн сан		3559.9		3347.5
тэтгэмжийн сан		372.9		372.9
ажилгүйдлийн сан		91.0		91.0
ҮОМШӨ-ний сан		433.5		586.1
ЭМД-ын сан		1087.6		1034.5
Сангийн зарлага бүгд		9224.6		11141.8
үүнээс: тэтгэврийн сан	3311	5929.3	3600	7216.8
тэтгэмжийн сан	1603	370.3	1972	460.0
ажилгүйдлийн сан	252	114.1	135	115.1
ҮОМШӨ-ний сан	832	1243.8	894	1245.0
ЭМД-ын сан	62097	1567.1	70517	2104.9

Тайлант хугацаанд нийгмийн даатгалын сангаас 3600 хүнд 7216.8 сая төгрөгийн тэтгэвэр, 1972 хүнд 460.0 сая төгрөгийн тэтгэмж, 894 хүнд 1245.0 сая төгрөгийн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний тэтгэмж, 70517 хүнд 2104.9 сая төгрөгийн эрүүл мэндийн даатгал, 135 хүнд 115.1 сая төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмжийг тус тус олгосон байна.

**НИЙГМИЙН ХАЛАМЖ:** 2014 оны эхний 8 сарын байдлаар нийгмийн халамжийн сангийн 20.0 хувь буюу 323.4 сая төгрөг улсын төсвөөс, 79.9 хувь буюу 1292.5 сая төгрөг орон нутгийн төсвөөс, 0.1 хувь буюу 0.9 сая төгрөг бусад орлогоор санхүүжигдсэн байна.



Зураг 5. Нийт орлого - 1616.8 сая

## Хүснэгт 4. Нийгмийн халамжийн сангийн орлого, зарлага


Үзүүлэлт	Мян төг	Хүний тоо
Нийгмийн халамжийн сан бүгд	1616819.2	
үүнээс улсын төсвөөс	323400.0	
орон нутгийн төсвөөс	1292497.6	
бусад орлого	921.6	
Нийгмийн халамжийн сангийн зарлага бүгд	1566485.5	7939
үүнээс:Тэтгэвэр	484449.5	537
Тэтгэмж	225380.1	542
Жирэмсэн эхчүүдийн тэтгэмж	245624.1	775
Ахмад дайчин, гавьяатын нэмэгдэл	29599.7	20
"Алдарт эх" 1 одонтой эхчүүд	151400.0	757
"Алдарт эх" 2 одонтой эхчүүд	125200.0	1252
Ахмад настанд үзүүлсэн хөнгөлөлт	193812.4	1791
ХБИргэнд үзүүлсэн хөнгөлөлт	39687.9	181
ОНО-д түшиглэсэн халамжийн үйлчилгээ	28786.0	828
Бусад үйлчилгээ	42545.8	35

Тайлант хугацаанд халамжийн сангаас 537 хүнд 484.4 сая төгрөгийн тэтгэвэр, 542 хүнд 225.4 сая төгрөгийн тэтгэмж, 775 жирэмсэн эхчүүдэд 245.6 сая төгрөгийн тэтгэмж, 20 ахмад дайчин, гавьяат цолтой хүнд 29.6 сая төгрөг, алдарт эхийн одонтой 2009 эхчүүдэд 276.6 сая төгрөг, 1791 ахмад настанд 193.8 сая төгрөг, 181 хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд 39.6 сая төгрөгийн хөнгөлөлт тус тус олгосон байна.

Харин олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд 828 иргэн хамрагдаж 28.7 сая төгрөг хүртсэн байна.

**НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭ:** Энэ оны эхний 8 сарын байдлаар нийтийн аж ахуй үйлчилгээний салбарын нийт орлого 1093.8 сая төгрөг болж өнгөрсөн оны мөн үеийнхээс 46.2 хувиар буюу 345.8 сая төгрөгөөр өссөн байна. Мөн нийт орлогын 572.2 сая төгрөг буюу 52.3 хувь нь хүн амаас оруулсан орлого эзэлж байна.

Зураг 6. Орлогын төлөвлөгөөний биелэлт



## Хүснэгт 5. Орон сууц нийтийн аж ахуйн орлого

/мянган төгрөг/

Үзүүлэлт	2013 он	2014 он	Өсөлт бууралт
Орон сууц	138975.5	139736.8	761.3
Ус борлуулалт-бүгд	304986.2	334680.8	29694.6
үүнээс: хүн амд	187104.9	212207.4	25102.5
аж ахуйн нэгжид	113274.2	117501.0	4226.8

үйлчилгээний байгууллагад	4607.1	4972.5	365.4
Сувагжуулалт	274852.6	294393.1	19540.5
Бусад	29201.6	45078.9	15877.3
Татаас		280000.0	280000.0
Дүн	748015.9	1093889.7	345873.8

СУУЦ ӨМЧЛӨГЧДИЙН ХОЛБОО: Тайлант хугацаанд дүүргийн СӨХ-дын орлогын төлөвлөгөөний биелэлт доорх байдалтай байна.

Хүснэгт 6. Сууц өмчлөгчдийн холбоодын орлогын байдал /мянган төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	ТБ%
Тавлаг өргөө	41655.6	41284.9	99.1
Маргад өргөө	35920.0	33484.6	93.2
Сод хөгжил	39111.2	50014.7	127.9
Шинэ элч	40171.3	39345.3	97.9
Уурхайчин	33642.0	28047.2	83.4
НИЙТ ДҮН	190500.1	192176.7	100.3

ЭРҮҮЛ МЭНД: Дүүргийн эрүүл мэндийн нэгдлийн мэдээлснээр эхний 8 сарын байдлаар 579 эх амаржиж, 584 хүүхэд төрүүлснээс гадны 88 эх амаржсан байна. Тайлант хугацаанд 162088 хүн амбульторын үзлэгт хамрагдсан нь өнгөрсөн оны мөн үеэс 21456 хүнээр буюу 15.3 хувиар, 4499 хүн хэвтэн эмчлүүлсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 89 хүнээр буюу 2.0 хувиар тус тус өссөн байна.

Хүснэгт 7. Бүртгэгдсэн халдварт өвчин

Үзүүлэлт	2013 он	2014 он	Өсөлт бууралт	
Халдварт паразит өвчин	239	196	-43	
үнээс:	Заг хүйтэн	82	50	-32
	Тэмбүү	64	63	-1
	Мөөгөнцөр	-	7	7
	Трихомноз	41	45	4
	Сүрьеэ	35	25	-10
	Кандидоз	17	6	-11
Цочмог халдварт өвчин	160	90	-70	
үнээс:	Цусан суулга	13	19	6
	Гепатит А	18	5	-13
	Салхин цэцэг	28	55	27
	Гахай хавдар	83	3	-80
	Сальмонеллез	2	-	-2
	Роже	2	3	1
	Хачигт ректиоз	-	2	2
	Гар хөл амны өвчин	13	3	-10
	Скарлатин	1	-	-1
	Нийт халдварт өвчин	399	286	-113

Зураг 7. Халдварт өвчин /сараар/




Энэ оны эхний 8 сарын байдлаар халдварт өвчний 286 тохиолдол гарсан нь өнгөрсөн оны мөн үеэс 113 тохиолдлоор буюу 28.3 хувиар буурсан байна. Дүүргийн дунджаар 10000 хүн тутамд ногдох халдварт өвчнөөр өвчлөгсдийн тоо 105.0 продицмилль болсон нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 41.0 пунктээр буурсан байна.

Энэ хугацаанд халдварт паразит өвчин 196 болж нийт халдварт өвчний 68.5 хувийг эзэлж байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 43 тохиолдлоор буюу 18.0 хувиар, цочмог халдварт өвчин 90 тохиолдол байгаа нь нийт халдварт өвчний 31.5 хувийг эзэлж, өнгөрсөн оны мөн үеэс 70 тохиолдлоор буюу 43.7 хувиар тус тус буурсан байна.

**ГЭМТ ХЭРЭГ:** Дүүрэгт 2014 оны эхний 8 сарын байдлаар 160 гэмт хэрэг бүртгэгдсэн байгаа нь өмнөх оны мөн үеэс 18.8 хувиар буюу 37 хэргээр буурсан байна. Харин хэрэг илрүүлэлт 63.3 хувьтай байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 4.1 пунктээр нэмэгдсэн байна.

Зураг 8. Бүртгэгдсэн гэмт хэрэг /сараар/



**Хүснэгт 8. Бүртгэгдсэн гэмт хэрэг, төрлөөр**

Хэргийн төрөл	Хэргийн тоо		Хэргийн өсөлт	Дүнд эзлэх хувь
	2013 он	2014 он		
Хүн амь	1	-	-1	-
Хүчин	6	1	-5	0.6
Дээрэм	5	5	-	3.1
Танхай	7	6	-1	3.8
ББМГУчруулах	77	79	2	49.4
Ашиглах	3	-	-3	-
Хулгай	45	25	-20	15.6
<i>үүнээс: малын</i>	<i>11</i>	<i>1</i>	<i>-10</i>	<i>4.0*</i>
Булаалт	-	-	-	-
Залилан	8	-	-8	-
ХАБЭсрэг	13	12	-1	7.5
Гал түймэр	-	-	-	-
Бусад	32	32	-	20.0
<b>Бүгд</b>	<b>197</b>	<b>160</b>	<b>37</b>	<b>100.0</b>
<b>Хэрэг илрүүлэлт</b>	<b>59.2</b>	<b>63.3</b>		

\*-малын хулгайн хэргийг нийт хулгайн хэрэгт эзлэх хувиар тооцсон.

Нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 49.4 хувийг бусдын бие махбодид гэмтэл учруулах /ББМГУчруулах/ хэрэг, 15.6 хувийг хулгайн хэрэг, 20.0 хувийг бусад хэргүүд, 7.5 хувийг хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 3.8 хувийг танхайн хэрэг, 3.1 хувийг дээрмийн хэрэг, 0.6 хувийг хүчингийн хэрэг тус тус эзэлж байна. Малын хулгайн хэрэг 1 бүртгэгдсэн нь бүртгэгдсэн хулгайн хэргийн 4.0 хувийг эзэлж байна. Тайлант хугацаанд хүний амь, ашиглах, булаалт, залилангийн болон гал түймрийн хэргүүд бүртгэгдээгүй байна.


Зураг 9. Согтуугаар болон гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг



Хүснэгт 9. Согтуугаар болон гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг

Хэргийн төрөл	2013 он		2014 он	
	согтуугаар	гудамж талбайд	согтуугаар	гудамж талбайд
Хүн амь	1	-	-	-
Хүчин	1	-	-	1
Дээрэм	3	4	4	1
Танхай	7	6	5	1
ББМГУчруулах	51	24	46	23
Хулгай	4	2	3	3
Залилан	-	2	-	-
ХАБЭсрэг	5	1	2	1
Бусад	5	9	10	8
Бүгд	77	48	70	38
Дүнд эзлэх хувь	39.1	24.4	43.8	23.8

Зураг 10. Согтуугаар болон гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг



нэмэгдсэн байна.


2014 оны эхний 8 сарын байдлаар согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 70 байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 9.1 хувиар буюу 7 хэргээр буурсан байна. Энэ нь тайлант хугацаанд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 43.8 хувийг эзэлж байгаа бөгөөд өнгөрсөн оны мөн үеэс 4.7 пунктээр



Тайлант хугацаанд гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг 38 болж өнгөрсөн оны мөн үеэс 20.8 хувиар буюу 10 хэргээр буурсан ба нийт гэмт хэргийн 23.8 хувийг эзэлж, өнгөрсөн оноос 0.6 пунктээр буурсан байна.

**БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД:** Оны эхний 8 сарын байдлаар дүүрэгт ажил идэвхтэй хайж байгаа ажилгүй иргэд 360 байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 24.8 хувиар буюу 119 хүнээр, эмэгтэй ажилгүй иргэд 217 байгаа нь өмнөх оны мөн үеэс 9.2 хувиар буюу 22 хүнээр тус тус буурсан байна.

Зураг 11. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн хөдөлгөөн



Тайлант сард бүртгэлээс 140 иргэн хасагдсан байхад ажил идэвхтэй хайж байгаа 134 иргэн шинээр бүртгүүлсэн бөгөөд үүний 59.7 хувь нь буюу 80 нь эмэгтэйчүүд байна. Харин 27 иргэн ажилд зуучлуулан орсон ба үүнээс:

- Хязгаарлагдмал хариуцлагатай компанид – 7
- Бусад байгууллагад – 20 иргэн ажилд орсон байна.

Хүснэгт 10. Бүртгэлтэй ажилгүй иргэд, насны бүлгээр:

Үзүүлэлт	2013 он	Дүнд эзлэх хувь	2014 он	Дүнд эзлэх хувь
16-24 нас	160	33.4	144	40.0
25-34 нас	159	33.2	96	26.7
35-44 нас	97	20.3	56	15.6
45-60 нас	63	13.2	64	17.8
Бүгд	479	100.0	360	100.0

2014 оны 8 сарын байдлаар ажил идэвхтэй хайж байгаа бүртгэлтэй ажилгүй иргэдийг насны бүлгээр харахад 40.0 хувь нь 16-24 насны, 26.7 хувь нь 25-34 насны, 15.6 хувь нь 35-44 насны, 17.8 хувь нь 45-60 насны ажилгүй иргэд эзэлж байна.

Хүснэгт 11. Бүртгэлтэй ажилгүй иргэд, боловсролоор:

Үзүүлэлт		Ажилгүй иргэд		Бүгдэд эзлэх хувь	
		2013 он	2014 он	2013 он	2014 он
Бүртгэлтэй ажилгүй иргэд		479	360	100.0	100.0
Үүнээс	Дээд	167	135	34.9	37.5
	Тусгай дунд	36	30	7.5	8.3
	Мэргэжлийн анхан шатны	34	37	7.1	10.3
	Бүрэн дунд	202	132	42.2	36.7

Бүрэн бус дунд	29	18	6.1	5.0
Бага	8	7	1.7	1.9
Боловсролгүй	3	1	0.6	0.3

Тайлант сарын байдлаар ажил идэвхтэй хайж байгаа ажилгүй иргэдийг боловсролын түвшингээр ангилж үзэхэд 37.5 хувийг дээд, 8.3 хувийг тусгай дунд, 10.3 хувийг мэргэжлийн анхан шатны, 36.7 хувийг бүрэн дунд, 5.0 хувийг бүрэн бус дунд, 1.9 хувийг бага боловсролтой 0.3 хувийг боловсролгүй иргэд эзэлж байна.


Зураг 12. Бүртгэлтэй ажилгүй иргэд /боловсролоор/



ҮНЭ ХАНШ: 2014 оны 8 сарын хүнсний өргөн хэрэглээний 19 нэр төрлийн бүтээгдэхүүний дундаж үнийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад дараах байдалтай байна.

Хүснэгт 12. Өргөн хэрэглээний барааны дундаж үнэ /жил бүрийн 8 сарын байдлаар/

Барааны нэр төрөл	Х\н	2011	2012	2013	2014	2014 % 2013
1. Гурил /дээд/	кг	956	900	1100	1200	109.1
2. Гурил 1-р зэрэг /алтан тариа/	кг	731	750	765	1100	143.8
3. Гурил 2-р зэрэг /алтан тариа/	кг	561	525	575	900	156.5
4. Цагаан будаа	кг	1656	1650	1800	2200	122.2
5. Шар будаа	кг	1538	1550	1600	1500	93.8
6. Хонины мах	кг	4056	7300	7719	7950	103.0
7. Үхрийн мах	кг	4831	8187	9250	9100	98.4
8. Сүү	л	463	512	600	700	116.7
9. Тараг	л	656	750	900	1000	111.1
10. Цөцгийн тос	кг	3075	3000	3000	3100	103.3
11. Элсэн чихэр	кг	1600	1600	1600	1600	100.0
12. Монгол төмс	кг	1025	825	800	1260	157.5
13. Байцаа	кг	600	1337	850	840	98.8
14. Монгол лууван	кг	1400	1337	1488	2000	134.4
15. Манжин	кг	1075	937	1175	1240	105.5
16. Хятад бөөрөнхий сонгино	кг	900	1162	1200	1080	90.0
17. Монгол сонгино	кг	3000	2500	2125	1500	70.6
18. Ургамлын тос	ш	2700	2850	3050	3575	117.2
19. Өндөг	ш	220	265	273	350	128.2



Хүснэгт 13. Үйлчилгээний үнийн тариф /НӨАТ-гүй үнэ/

Үзүүлэлт	Айл өрхөд	Аж ахуйн нэгж байгууллагад	
Дулаан	1 м <sup>2</sup> =341 төг	1м <sup>3</sup> =697 төг	
Дулааны суурь тариф	40 м <sup>2</sup> хүртлэх=3000 төг	-	
	40м <sup>2</sup> - 80м <sup>2</sup> = 5000 төг		
	80м <sup>2</sup> -аас дээш = 10000 төг		
Халуун ус	Өвөл 1 хүн=1282 төг /тоолуургүй/ 1м <sup>3</sup> =700 төг /тоолууртай /	1гкал=41147 төг	
	Зун 1 хүн=1924 төг /тоолуургүй/ 1м <sup>3</sup> =1050 төг /тоолууртай /		
Цэвэр ус*	1 хүн=5106 төг /тоолуургүй/ 1 л=0.63 төг /тоолууртай/ Суурь хураамж =1800 төг	1 л=1.20 төг /тоолуургүй/ 1 л=1.15 төг /тоолууртай/ 1 л=4.41 төг /зөөврөөр/	
	Бохир ус*	1 хүн=4830 төг /тоолуургүй/ 1 л=0.58 төг /тоолууртай/	1 л=1.20 төг /тоолуургүй/ 1 л=1.15 төг/тоолууртай/

\*2014 оны 7 сарын 15-ны өдрөөс мөрдөж буй тариф

Хүснэгт 14. Түлш, шатахууны үнэ

Шатахууны нэр төрөл	2012 он	2013 он	2014 он	өөрчлөлт	
				төгрөг	хувь
АИ - 80	1470	1520	1560	40	2.6
АИ - 92	1610	1660	1700	40	2.4
Дизель түлш	1740	1790	1830	40	2.2

2014 оны 8-р сард түлш, шатахууны үнэ тогтвортой байсан бөгөөд өнгөрсөн оны мөн үеэс төрөл тус бүр литр тутамдаа 40 төгрөгөөр буюу 2.2 - 2.6 хувиар тус тус өссөн байна.

Зураг 15. Хот хоорондын зорчигч тээврийн үнэ /УБ-БН, БН-УБ/



Хүснэгт 15. Цахилгааны үнийн тариф /НӨТ-гүй үнэ/

Хэрэглэгчдийн ангилал	Хэмжих нэгж	Тариф /НӨАТ-гүй/
<i>* Айл өрхөд борлуулах цахилгааны тариф</i>		
Энгийн тоолууртай		
Сарын нийт хэрэглээний 150 кВт.ц	төг/квт.ц	84.0
Сарын нийт хэрэглээний 151 кВт.ц-аас дээш	төг/квт.ц	101.6
2 тарифт тоолууртай		
Өдрийн хэрэглээ /06.00-21.00/	төг/квт.ц	89.0
Орой, шөнийн хэрэглээ /21.00-06.00/	төг/квт.ц	65.0
Сарын суурь тариф	төг/сар	1000.0
<i>* Аж ахуйн нэгж, байгууллагад борлуулах цахилгааны тариф</i>		
Энгийн тоолууртай	төг/квт.ц	110.6
3 тарифт тоолууртай		
Өдрийн хэрэглээ /06.00-17.00/	төг/квт.ц	110.6
Оройн хэрэглээ /17.00-24.00/	төг/квт.ц	183.6
Шөнийн хэрэглээ /24.00-06.00/	төг/квт.ц	65.0

*\*2014 оны 8 сарын 10-ны өдрөөс мөрдөж буй тариф*

СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

2014 оны 9 дугаар сарын 8